

“УЛСЫН НӨӨЦ-60 ЖИЛ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

Монгол Улсад гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин ихээр сүйдэх зэрэг хүн, хуулийн этгээд, бүс нутгийн нөөц, боломжоос давсан хохирол учрах болон нийгэм, эдийн засгийн хямрал, дайны байдал зэрэг онцгой нөхцөл үүссэн үед үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, хүн амыг хоол хүнс, бусад бараа, материалаар хангах, хохирлыг бууруулах, даван туулах зорилгоор хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу ашиглах, улсын нөөцийн бараа материалын чанар аюулгүй байдал, логиستيкийн асуудал чухлаар тавигдаж байна.

Иймд бараа материалын чанар аюулгүй байдал, хадгалалтын нөхцөл, нөөц бүрдүүлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, инновацыг нэвтрүүлэх асуудалд эрдэмтэн судлаачдын анхаарлыг хандуулах хэрэгцээ шаардлагатай байна.

Энэхүү хурлыг Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөцийн газраас санаачлан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хоёр. Зорилго

Улсын нөөцийн эрх зүйн орчин, бараа материалын бүрдүүлэлт, хадгалалт, логиستيкийн чиглэлээр шинжлэх ухааны үндэстэй судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг идэвхжүүлэх, үр дүнг үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, инновац, нэвтрүүлэх, харилцан туршлага, мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх, улсын нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд судалгаа эрдэм шинжилгээний үндэстэй дэмжлэг үзүүлэхэд оршино.

Гурав. Хамрах хүрээ

Улс, орны аюулгүй байдлын чиглэлээр судалгаа хийж буй их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны төвүүд, судлаачид, ахисан түвшний суралцагчид болон Онцгой байдлын байгууллагын алба хаагчид.

Дөрөв. Хурлыг зохион байгуулагч

- Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөцийн газар,

Дэмжлэг үзүүлэх байгууллага:

- Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэн,

- Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургууль,
- мөн сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гамшиг судлалын төв.

Тав. Хуралд хэлэлцэх асуудлын ерөнхий агуулга

- Монгол Улсын нөөцийн өнөө ба ирээдүй (олон нийтэд нээлттэй түүхэн баримт, статистик дүн мэдээг ашиглаж болно);
- Бараа материалын чанар, аюулгүй байдал;
- Агуулахын инженерчлэл, автоматжуулалт, хиймэл оюун ухаан, инновацыг нэвтрүүлэх нь;
- Хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа;
- Гадаад улс орнуудын материаллаг нөөцийн эрх зүйн орчин, практик туршлага сургамж, хөгжлийн чиг хандлага.

Зургаа. Өгүүлэлд тавигдах ерөнхий шаардлага, заавар

- Хэлэлцүүлж буй илтгэлийн сэдэв нь хурлын зорилго, хамрах хүрээ, чиглэлд нийцсэн байх;
- Оюуны өмчийн эрхийг хүндэтгэн, хуулбарлалтын түвшинд анхаарч, эшлэлийг эрдэм шинжилгээний бүтээлд тавигдах шаардлагын дагуу ашигласан болно;
- Эрдэм шинжилгээний илтгэл нь бичлэгийн стандарт, шаардлагад нийцсэн байх;
- Хуудасны тоо 12-аас хэтрэхгүй (нүүр хуудас, хавсралт ороогүй) байх;
- Илтгэлийн эхийг Microsoft Word хэлбэрээр хүлээн авна.

Өгүүлэл бичих заавар:

Өгүүллийн нэр; Arial фондоор 12pt өндөртэй үсгээр, мөр хоорондын зай 1 байхаар, тод (Bold), том (Caps Lock) үсгээр голлуулан бичнэ.

Зохиогчийн овог, нэр; 10pt өндөртэй үсгээр, налуу (Italic) форматаар мөр голлон бичнэ. Зохиогчдын нэрийн баруун дээд өнцөгт тоогоор дугаарлан тэмдэглэж, нэрсийн дор албан газрын нэр бичсэн байна. 1-р зохиогчийн цахим хаяг, холбогдох утасны дугаарыг бичсэн байх.

Хураангуй; 15 мөр, 150-250 үгэнд багтааж бичнэ. 11pt өндөртэй үсгээр, italic форматтай бичигдэнэ.

Түлхүүр үг; 3-5 түлхүүр үг хэрэглэнэ. 11pt өндөртэй үсгээр, italic форматтай бичигдэнэ.

Судалгааны ажлын үндсэн хэсэг; Өгүүллийг Arial фондоор, мөр хоорондын зай 1,15 байхаар, А4 хэмжээний цаасан дээр зүүн гар талаас 30 мм, баруун гар талаас 15 мм, дээд, доод талаас 20 мм-ийн зай авч бичнэ.

Дүгнэлт, ашигласан материалын жагсаалт; Эш татсан эх сурвалжийг бичвэрийн холбогдох хэсэгт зүүлт эшлэлийн аргаар (insert footnote) хуудасны доод хэсэгт оруулна. Эшлэлийн эх сурвалжид зохиогч, эх сурвалжийн нэр, хэвлэгдсэн улс, хот, хэвлэгдсэн он, хэвлэгдсэн газар, хэмжээ (хуудасны тоо), хуудасны дугаар/тал, ISBN-ын дугаар зэргийг дэс дараалуулан бичнэ.

Санамж:

1. Өгүүллийг бичихдээ header, footer, footnote командыг ашиглахгүй. Мөн хуудасны дугаарыг тавихгүй.
2. Бүх математик бичлэгүүд MS Equation, MathType, LaTeX программаар бичигдэх бөгөөд 11pt өндөртэй байна. Томьёо нь дээд, доод талаасаа 11pt зайтай байх ба мөр голлон бичигдэнэ. Томьёоны дугаарыг тухайн мөрний төгсгөлд бага хаалтад бичнэ.
3. Scanner ашиглаж оруулсан бүдүүвч зураг болон фото зураг 300 dpi нягтаршилтай, зургийн *.TIF, *.JPG, *.BMP, *.GIF өргөтгөлтэйгөөр буулгагдаж, текст дотор мөр голлон байрласан байна.

Долоо. Илтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлт:

Ирүүлсэн илтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэж, эхний 7 илтгэлийг шалгаруулна. Үүнд:

- Хураангуй, түлхүүр үг;
- Шинжлэх ухааны үндэслэл, онолын үзэл баримтлал;
- Тодорхойлсон асуудал, түүний ач холбогдол, хэрэглээ, шинэлэг тал;
- Ашигласан судалгааны арга зүй, шинэ технологи, инновац;
- Мэдээлэл боловсруулалтын түвшин, судалгааны тооцоолол, үр дүн;
- Тодорхойлсон асуудлыг шийдвэрлэсэн байдал, онцлог зүйл;
- Хэрэглээнд нэвтрүүлэх боломжтой байдал;
- Илтгэл тавигдах шаардлагад нийцсэн байдал.

Хэлэлцүүлэгт шалгарсан илтгэлд тавигдах шалгуур үзүүлэлт:

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тавигдах форматад нийцсэн танилцуулгын программууд ашигласан байх;
- Танилцуулах мэдээлэл, слайдыг урьдчилан зохион байгуулагчид ирүүлсэн байх;
- Илтгэх ур чадвар, цаг ашиглалт;
- Цахим технологид нийцүүлэн илтгэгчийн бэлэн байдлыг хангасан байх;

- Илтгэлийг PowerPoint программ дээр 15 минутад танилцуулах ба асуулт, хариулт 10 минут үргэлжилнэ.

Найм. Хурлын зохион байгуулалт

Оролцогч эрдэм шинжилгээний өгүүллийг **2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 12:00 цаг** хүртэл kh.tserenpil@nema.gov.mn цахим хаяг болон **88005794** утасны дугаараар холбогдон ирүүлнэ.

Хурлыг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 09:00 цагт Онцгой байдлын ерөнхий газрын Соёлын төвд танхимын хэлбэрээр зохион байгуулна.

Ирүүлсэн бүтээлийг эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх, эмхэтгэлд хэвлүүлэх гэсэн хэлбэрээр хүлээн авна. Хуралд хэлэлцүүлэх илтгэлийг урьдчилан мэдэгдэнэ.

Шалгаруулалт:

Эрдэм шинжилгээний хуралд ирүүлсэн бүтээлийг шүүгчдийн багийн нэгдсэн үнэлгээгээр дүгнэх ба хоёр үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

- 1-р шатны шалгаруулалтыг дүгнэх шалгуур үзүүлэлтийн дагуу 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр 7 илтгэлийг шалгаруулж, оролцогчдод албан ёсоор хариуг мэдээлнэ.
- 2-р шатанд шалгарсан илтгэлийг 2025 оны 06 дугаар сарын 18-ны Лхагва гарагт 09:00 цагаас танхимаар хэлэлцүүлж, шилдэг 3 илтгэлийг шалгаруулна.

Жич: Шалгарсан илтгэлүүдээс Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөл, Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Гамшиг судлал, инноваци” ISBN 978-99978-4-636-5, Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулиас эрхлэн гаргадаг “Гамшгийн эрсдэл судлал” ISSN: 2960-2017 дугаартай мэргэжлийн сэтгүүлийн шаардлага хангасан тохиолдолд 2025 оны II хагас жилийн дугаарт хэвлүүлэн, нийтийн хүртээл болгоно.

Ес. Уралдааны шагналын сан

I байр Өргөмжлөл, 2,000,000 төгрөгийн мөнгөн шагнал;

II байр Өргөмжлөл, 1,500,000 төгрөгийн мөнгөн шагнал;

III байр Өргөмжлөл, 1,000,000 төгрөгийн мөнгөн шагнал.